



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 00

Мандалговь

Г

О.Нандин-Эрдэнийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Цагаандэлгэр сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Цагаандэлгэр сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Отгонбаатарын Нандин-Эрдэнэ 64.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа О.Нандин-Эрдэний холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ТӨРБАТ

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын
10-ны өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт



**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Цагаандэлгэр сумын
хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн О.Нандин-Эрдэний тухай дүгнэлт**

1. О.Нандин-Эрдэнэ нь 1995 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд төрсөн. 27 настай, эмэгтэй
2. Боловсролын байдал: 2012-2016 онд Монгол улсын их сургуулийг нийгмийн ажилтан мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. О.Нандин-Эрдэний тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Цагаандэлгэр сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ